64.			8.Салбарын ЭШБ, ТББ-уудын нэгдсэн судалгаа гаргах, удирдлагыг мэдээллээр хангах, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн санал хүсэлтийг удирдлагад уламжлах, яамтай хамтран иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцоно. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна. Шуурхай байна. Хугацаа: Жилдээ	Салбарын ТББ болон мэргэжлийн холбоодын талаарх мэдээллийг нэгтгэн гаргаж Сайд болон удирдлагыг тухай бүр мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн Бодлогын Зөвлөлд орохоор саналаа ирүүлж байгаа ТББ болон мэргэжлийн холбоодын саналыг тухай бүр сайд болон холбогдох хүмүүст танилцуулж байна. УУЯ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар саналаа ирүүлсэн ТББ мэргэжлийн холбоодын санал болон санамж бичгийн төслийг тухай бүр хянаж завсарыг хийж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуультай хамтран ажиллах санал ирүүлснийгсудалж үзээдСанамж бичгийн хүрээндхамтранажиллахсаналыгхүргүүлсэн. ГУУС-аас Санамж бичгийн төслийгирүүлээдбайна. УулуурхайнсалбарынмэргэжлийндээвэрхолбооноосСанамжбичигбайгуулах саналирүүлснийгсудалжбайна. Салбарын ТББ-уудаас зохион байгуулсан Монголын геологи, хайгуул 2015 чуулганд 3 сарын 19-21-нд зохион байгуулагч, дэмжигчээр УУЯ, ГБХ оролцсон. Сайдын Геологийн салбарын төрийн болон ТББ, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагуудын удирдлага, төлөөллүүдтэй уулзах уулзалтыг 2015.01.15-нд УУЯ-н дээр зохион байгуулсан. Уулзалтын мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөө УУС-ын 2015.02.13-ны №28 тушаалаар батлагдсан. Салбарын төрийн өмчит байгууллагууд болон их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны нэгтгэл мэдээллийг гаргаж, удирдлагад хүргүүлсэн. ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуультай хамтран ажиллах санал ирүүлснийг судалж үзээд Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах саналыг хүргүүлж саналыг тусган Санамж бичгийг байгуулсан. УУЯ, МУИС, ШУТИС хамтарсан “Монголын гео-шинжлэх ухааны нэр томъёоны асуудал” сэдэвт семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулав. МГУУМИ-тэй хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд салбарын мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх ажлыг шилжүүлэх талаар санал бэлтгэж удирдлагуудад танилцуулсан.	27	

				Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг хэрэгжүүлж эхлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах тухай тушаалын төсөл боловсруулан түүнд Салбарын ЭШБ, ТББ-уудын нэгдсэн судалгаа гаргах, удирдлагыг мэдээллээр хангах удирдамжийг тусгаж өгсөн. Салбарын ТББ-уудаас зохион байгуулсан Монголын геологи, хайгуул 2015 чуулганд 3 сарын 19-21-нд зохион байгуулагч, дэмжигчээр УУЯ, ГБХ оролцсон. Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа ажлын чанар үр өгөөжийн асуудлаар МҮГХ-ноос санаачлан зохион байгуулсан хэлэлцүүлэгт 12 сард оролцов. ШУТИС-ийн ГУУС, МУИС-ийн БУС-ын ГГТ-ийн 2015 оны бакалавр, магистрын төгсөлтийн дипломын хамгаалалтын комисст 1, 6 сард ажиллав. Монголын үйлдвэрлэлийн геологчдийн холбооны удирдах зөвлөлийн хуралдаанд Төрөөс явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сурталчилж тухай бүр оролцов, ШУА-ийн Газарзүй, геологийн бага чуулган, Палеонтологи, геологийн хүрээлэн, ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн эрдмийн зөвлөлийн хуралдаанд тухай бүр санал өгч оролцов. Биелэлт 100%		
65.			9. Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой УИХ-ын Байнгын хорооны 2013 оны 13 тоот тогтоолын уул уурхайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлуудын биелэлтийг тогтсон хугацаанд нэгтгэн гаргаж, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна. Шуурхай байна. Хугацаа: Жилдээ	Хүний эрхийн комисст 2 удаагийн мэдээллийг хүргүүлсэн. Мөн хүний эрхийн комиссоос болон бусад байгууллагаас зохион байгуулсан уул уурхайн салбар дахь хүний эрхийн асуудал болон Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлаарх мэдээллийг тухай бүр хүлээн авч удирдлагуудад танилцуулан мэдээллээр хангаж ажилласан. Биелэлт 100%	30	
26.	69.	1.3.11 Тус яаманд ашиглагдаж буй Монголын цахилгаан холбооны суурин утас болон төрийн холбооны утас, кабелийн телевизийн сүлжээ,	1. Найдвартай ажиллагааг хангаж ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Чанарын шаардлага хангасан байна. Хугацаа: Жилдээ	Интернэтийн үйлчилгээг “Комтел” ххк-тай гэрээг сунгаж ажилласан. Кибер аюулгүй байдлын газар, Мэдэлээл шуудан, харилцаа холбооны газаруудтай хамтран мэдээллийн аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийж зөвлөгөө авч хамтран ажиллаж байна. Мөн хорт кодыг Кибер аюулгүй байдлын газартай хамтран ажиллаж илрүүлж усгах арга хэмжээ авч байна. Сүлжээний, техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг тогтмол ханган ажиллаж байна.	30	

		хурлын заалны акустик дууны системийн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангах арга хэмжээ авч шийдвэрлүүлнэ.		Биелэлт 100%		
	70.		2.Сүлжээний тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Чанарын шаардлага хангасан байна. Хугацаа: Жилдээ	Дотоод удирдлагын системийг шинэчлэх ажлын хүрээнд программын хөгжүүлэлт хийдэг компаниудаас үнийн санал, танилцуулга авч харьцуулсан судалгаа хийж Эйбл дотоод удирдлагын системийг сонгож нэвтрүүлэлтийг төвөлвөгөөний дагуу хийж гүйцэтгэж байна. Мөн мэдээлэл технологийг ашиглах журам боловсруулж байна. Биелэлт 100%	27	
27.	71.	1.3.12 Компьютерын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дотоод сүлжээний эвдрэл гэмтлийг илрүүлж, шуурхай арилгах арга хэмжээ авна.	1. Гарсан гэмтлийг шуурхай арилгах арга хэмжээ авна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	Тухай бүр гарсан техникийн болон сүлжээний доголдол, гэмтлийг цаг алдалгүй оношилж, шаардлагатай сэлбэг хэрэгслийг сольж суурьлуулж, хэвийн үйл ажиллагаанд оруулж байна. Биелэлт 100%	27	
29.	78.	1.3.14.Сайд (ТЕЗ)-ын төсвийн багцын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн баталгаажуулж дүнг ТЕЗ(сайд)-д танилцуулан холбогдох газруудад хүргүүлнэ.	1.Сайдын багцын харъяа байгууллага, төслүүдийн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шалгаж хүлээн авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	УУСайдын багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд шалган хүлээн авч шаардлага хангахгүй зарим тайланг буцаан засуулах арга хэмжээ авч ажилласан. УУСайдын багцад: УУЯ, ГТГ, АМГ, УУАА, УУ хөрөнгө оруулалт, геологи судалгааны төсдүүд, Тогтвортой бичил уурхай төсөл, Уул уурхайн бохирдлыг тогтоох төслүүд хамрагдлаа. Мөн өглөг авлагын тооцоо нийлсэн акт, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн баталгаа, төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад шардлагатай баримт материалыг шаардан авсан. Биелэлт 100%	30	
	79.		2.Сайдын багцын харъяа байгууллагуудын санхүүгийн тайланг "Plastic" программд нэгтгэн Сайдын багцын нэгдсэн санхүүгийн тайланг гаргаж, удирдлагад танилцуулан, баталгаажуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	Сайдын багцын харъяа байгууллагуудын санхүүгийн тайланг "Plastic" программд нэгтгэн Сайдын багцын нэгдсэн санхүүгийн тайланг гаргаж, удирдлагад танилцуулан, баталгаажуулж ажиллав. Мөн Сангийн яамнаас харъяа байгууллагын тайланг цахимаар авах болсонтой холбогдуулан Сангийн яамны сайтад тайлангуудыг оруулж, тооцоо нийлж ажиллаа. Биелэлт 100%	30	

30.	80.		3.Сайдын багцын эхний хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг тайлбар, тодруулгын хамт 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	Сайдын багцын эхний хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг тайлбар, тодруулгын хамт хуулийн хугацаанд Сангийн яам, Үндэсний аудитын газарт дүгнэлт гаргуулахаар хүргүүлж ажилласан. Биелэлт 100%	30	
	81.		4.ТЕЗ-ийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор УАГ-т, 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	ТЕЗ-ийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 05-ны дотор УАГ-т, 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор Сангийн яаманд албантоотоор хүргүүлж, УАГ-аас гаргасан Уул уурхайн сайдын сайдын багцын санхүүгийн тайлангийн дүгнэлтийг 5 сарын 1-ны өдөр сайдад гардуулав. УАГ-ын дүгнэлтээр УУСайдын багцын тайланд зөрчилгүй дүгнэлт гаргасан. Биелэлт 100%	30	
	82.	1.3.15.Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэхүй л ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. /Сайдын тушаал 2015.02.13-ны өдрийн 28 тоот тушаал/	1.Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хугацаа: Жилдээ	Налайхын уурхайгаас тэтгэвэрт гарсан ахмад уурхайчдаас ирүүлсэн өргөдлийнхүрээндсудалж үзээдГеологиуулуурхайнсалбараасхүнд, хортойнөхцлөөртэтгэвэртгарчбайгаахүмүүсийнхувьхэмжээнийасуудлыгший двэрлэхталаархамтарчажиллахталаар Хөдөлмөрийняамандсаналаахүргүүлээдбайна. Геологи, уул уурхайн салбарын 2015-2016 оны хамт/тариф/-ын хэлэлцээрт Ахмад геологчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэхасуудлыгтусганажиллажбайна. Хэлэлцээрт 3 талгарын үсэгзуржбаталгаажууланХөдөлмөрийн яаманд бүртгүүлсэн. Тэтгэвэртээ гарсан харъяалах байгууллагагүйахмадуудыгхаръяаагентлаг,байгууллагуудадхамруулахасууд лыгэрдэсбаялгийнсалбарыннэгдсэнахмадынхолбоотойхамтранзохионбайгу улжСаршинийнбаяр, ахмадынбаярыгтохиолдууланхүндэтгэл үзүүлэнажиллажбайна. Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг яамны хэмжээнд холбогдох газруудаас гаргуулан ХШУДАГ-аар үнэлгээг хийлгэн нэгтгэн удирдлагад танилцуулсан. Биелэлт 100%	21	
1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭР БОЛОВСРУУЛАХАД ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТАЛААР ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ГОЛ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						

1.1.1 Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор хууль тогтоомжийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад эрх зүйн зөвлөгөө өгөх зорилтын хүрээнд:						
1.2.2 Төрийн нарийн бичгийн дарга, Дэд сайд, Сайдыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь эрх зүйн зөвлөгөө өгөх зорилтын хүрээнд:						
9.	20.	1.9.Уул уурхайн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн биелэлттэй холбогдсон арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах, өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг хангах, сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.	1. Тушаал, шийдвэрийн биелэлттэй холбогдсон арга хэмжээг нэгтгэн хяналт тавих Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Тушаал, шийдвэрүүдийг хяналтад авч, хэрэгжилтийг удирдлагад танилцуулсан байна. Хугацаа: Жилдээ	Уул уурхайн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг нэгдсэн хяналтад авч удирдамж, чиглэлийн дагуу байнгын хяналт тавин ажиллаж байна. Шивээ-Овоогийн нүүрсний орд газрын тусгай зөвшөөрлийн асуудлыг цэгцлэх, дүгнэлт гаргах ажлын хэсэг Засгийн газрын хуралдаанаар 2013.07.06-ны өдөр хэлэлцүүлж тэмдэглэл гаргуулсан. Уг асуудлыг цагдаагийн байгууллага шалгаж байгаа тул хүлээгдэж байна.Өндөр цагааны ховор метал, Мөнгөн өндөрийн ордын нөөц, түүний хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байдал, өнөөгийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Хууль тогтоомжид нийцсэн эсэх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарах эсэх асуудлыг судалж дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг тус ордуудын талаарх материалуудыг бэлтгэсэн. “Олон овоот” ордын талаарх мэдээллүүдийг судалж санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг 2 удаа хуралдаж, удирдамжийн дагуу ажиллаж холбогдох урьдчилсан санал, дүгнэлт гарсан. Ерөнхий сайдын 2015 оны 56-р захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, Уул уурхайн сайдын 2015 оны 52-р тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй төрийн эзэмшлийн хувь тогтоох, орд ашиглах гэрээний төслийг боловсруулах, шийдвэрлэх Ажлын хэсэг ажиллаж, санал дүгнэлт боловсруулан УИХ-д өргөн барьсан. УИХ 2015.06.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох бэлтгэл ажлын талаарх холбогдох танилцуулгыг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.“Ихтохойрол” ХХК нь Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумдын нутагт MV-004121, MV-007712 , MV-007713 , MV-017263 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг бөгөөд дээрх талбайнууд нь Улсын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр баталсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”, Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 174 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн “Хилийн заагийгтогтоох тухай” 194 дүгээр тогтоолоор	27	

				баталсан ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон хилийн заагтай хэсэгчлэн давхцсан тул үйл ажиллагааг нь зогсоосон. Энэ нь “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын гэрээ”-тэй зөрчилдөж байж болзошгүй гэж үзэн хууль, тогтоолд өөрчлөлт оруулах боломжийг судалж газар дээр нь ажиллан дүгнэлт гаргах Ажлын хэсгийг Уул уурхайн сайдын 2014 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 194 дүгээр тушаалаар байгуулав. Ажлын хэсгийн явцын тайланг АНУ-ын ЭСЯ-ны төлөөлөлд ажлын хэсгийн гишүүд танилцуулсан. АНУ-ын ЭСЯ-ны төлөөлөлтэй хийсэн уулзалтанд орж “Их тохойрол”-ын ажлын хэсгийн ажлын явцын талаар танилцуулсан. Ашигт малтмалын “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулж Уул уурхайн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 10 тоот тушаалаар батлуулсан. “Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөх журам, дүрэм, гэрээний загварыг боловсруулж, батлуулах” үүрэг бүхий ажлын хэсэг тайлант хугацаанд нийт 4 удаа хуралдаж, явц байдлыг Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Журмын төслүүдийг боловсруулах ажил хийгдэж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаахудаг уурхайгаас Гашуунсухайт боомт чиглэлийн төмөр зам дайран өнгөрч байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 94 дугаартай батлагдсан "Алтны олборлолтыг нэмэгдүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх тухай тогтоол"-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд үндсэн ажлын хэсэг ажилласан. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг үндэслэл болгон Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ЗГ-ын 2011 оны 174, 2012 оны 194 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж ЗГ-ын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн. Биелэлт 100%		
		2.Тушаал, хэрэгжилтийн тайлагнах	шийдвэрийн биелэлтийг	2012-2015 онд Уул уурхайн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдээс гүйцэтгэлээ тайлагнаж	27	

			Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тушаал, шийдвэрүүдийг хяналтад авч, хэрэгжилтийг удирдлагад танилцуулсан байна. Хугацаа: Жилдээ	хаагаагүй 107 ажлын хэсгийн судалгааг гаргаж удирдлагад танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн дарга, холбогдох мэргэжилтэнтэй уулзаж тайлбар судалгааг авч нэгтгэж 99 ажлын хэсгийг Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар хаасан байна. Жилийн эцсийн байдлаар 40 ажлын хэсэг ажиллаж байна. Биелэлт 100%		
31.	83.	1.1.2.1.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газрын тогтоолын төсөлд сайдаас өгөх саналын төслийг боловсруулж танилцуулах, хүргүүлэх арга хэмжээ авна.	1.Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төсөлд Сайдаас өгөх санал боловсруулж хүргүүлнэ. Тоо хэмжээ: Өдөр тутам Чанар: Ирүүлсэн төсөлд хууль зүйн, санал дүгнэлтийг өгсөн байна. Хугацаа: Жилдээ	Засгийн газрын гишүүдээс санал авахаар ирүүлсэн Засгийн газрын тогтоолын төсөлд тухай бүрт Сайдаас өгөх саналыг боловсруулж хүргүүлсэн.Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд Сайдаас өгөх саналыг тухай бүр боловсруулж хүргүүлж ажилласан. -УТХ-өөр хэрэгжүүлж байгаа ГСА-ын 2014 оны явц, үрдүн, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж, ЗГ-т хүргүүлэн хэлэлцүүлсэн. -Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан ЗГ-т хүргүүлсэн. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 78 дугаар захирамжаар байгуулсан “Газар доор уусгах аргаар уран олборлоход хүхрийн хүчил хэрэглэх стандартын төслийг боловсруулах” ажлын хэсгээс “Шар нунтагт тавих техникийн шаардлага”, “Хүхрийн хүчлийн техникийн шаардлага” стандарт, “Газар доор хүхрийн ураныг хүчлээр уусган олборлох технологийн шаардлага” техникийн зохицуулалтыг боловсруулсан. -Цацраг идэвхт ашигт малтмалын эрэх ,хайх, ашиглах үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уулзурхайн сайдын 2015 оны 19 дүгээрт тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж холбогдох саналыг боловсруулан, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд Сайдаас өгөх саналыг тухай бүр боловсруулж хүргүүлж ажилласан. -УТХ-өөр хэрэгжүүлж байгаа ГСА-ын 2014 оны явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж, ЗГ-т хүргүүлэн хэлэлцүүлсэн. -Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан ЗГ-т хүргүүлсэн. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 78 дугаар захирамжаар байгуулсан “Газар доор уусгах аргаар уран олборлоход хүхрийн хүчил хэрэглэх стандартын төслийг боловсруулах” ажлын хэсгээс “Шар нунтагт тавих техникийн шаардлага”, “Хүхрийн хүчлийн техникийн шаардлага” стандарт, “Газар доор хүхрийн ураныг хүчлээр уусган олборлох технологийн шаардлага” техникийн зохицуулалтыг боловсруулсан. -Цацраг идэвхт ашигт малтмалын эрэх ,хайх, ашиглах үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул	30	

			уурхайн сайдын 2015 оны 19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж холбогдох саналыг боловсруулан, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. -Гадаад хэргийн яамнаас боловсруулсан Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийн төслийн танилцуулга, тус хэлэлцээрийн төсөл болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлтэй танилцаж зарчмын хувьд дэмжив. -Сангийн яамнаас боловсруулсан “Төрийн банк үнэт цаас гаргах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгатай танилцаж зарчмын хувьд дэмжив. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Концессын төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийг Концессын тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.2 заалтыг үндэслэн боловсруулахад анхаарах саналыг хүргүүлэв. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Худалдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг ирүүлсэнтэй танилцаж холбогдох 7 саналыг боловсруулан хүргүүлэв. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Концессын төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, Засгийн газрын тогтоолын төслийн үндэслэх хэсэгт заасан засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5 дах заалт нь Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал байх тул хасах, мөн тогтоолын үндэслэл хэсэгт концессын тухай 6 дугаар зүйлийн 6.2 дах заалтыг тусгах нь зүйтэй гэсэн саналыг хүргүүлэв. -Татварын ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дах заалтад татварын алдангийн хэмжээг арилжааны банкнаас олгож буй зээлийн хүүгийн дунджийг үндэслэн жил бүр тогтоож байхаар заасны дагуу Сангийн яамнаас боловсруулсан “Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаас 2015 онд худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах төсөл арга хэмжээний жагсаалтыг батлахаар боловсруулсан Монгол Улсын засгийн газрын “Жагсаалт батлах тухай” тогтоолын төсөлтэй танилцаж холбогдох 2 саналыг боловсруулан Монгол Улсын Шадар сайдад хүргүүлэв. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -Аж үйлдвэрийн яамнаас Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 70.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр боловсруулсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын хуралдааны		
--	--	--	--	--	--

			тэмдэглэл, тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, Засгийн газрын тогтоолын танилцуулгад “ ... дээрх төслүүдийг санхүүжүүлэхэд шаардлагатай 767.1 тэрбум төгрөгнөөс эхний ээлжинд нэн шаардлагатай байгаа 70.0 тэрбум төгрөгний эх үүсвэрийг Хөгжлийн банкны эх үүсвэрээр шийдвэрлэх хэрэгцээ байна.” гэсэн байх бөгөөд эдгээр төслүүдийг яагаад эхний ээлжинд оруулах болсон болон нэн шаардлагатай 70.0 тэрбум төгрөгийн задаргаа ба хэрэгцээг тодорхойлоогүй байгаа тул эдгээр асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах танилцуулгад тодорхой болгож оруулах нь зүйтэй гэсэн саналыг хүргүүлэв. -Сангийн яамнаас боловсруулсан “Зээлийн багцын нөхцлийн тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, холбогдох танилцуулгатай танилцаж, зарчмын хувьд дэмжив. -Сангийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Санхүүжилтийн тухай” тогтоолын төсөлтэй танилцаж, холбогдох 4 саналыг хүргүүлэв. -Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Санхүүгийн түрээсийн үйлчилгээ нэвтрүүлэх, баталгаа гаргах тухай” тогтоолын төсөлтэй танилцаж дэмжив. -Сангийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Зээл авах, зээлийн баталгаа гаргах тухай” тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэл, холбогдох танилцуулгатай танилцаж, Уул уурхайн яаманд Хөгжлийн банкны 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2/1284 тоот албан бичгээр ирүүлсэн зээлийн баталгаа гаргуулах асуудлыг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг Сангийн яаманд уламжилсан. Сангийн яамны 2015 оны 01 сарын 28-ны өдрийн 7-1/469 тоот албан бичгээр ОХУ-ын эдийн засгийн төлөв байдал тогтворгүй байгаа өнөө үед ОХУ-ын рублээр тооцож хэлэлцээр хийх нь оновчтой гэж үзэж байна. Энэ нь зээлийн зардлыг бууруулж, гадаад худалдаанаас үүсч буй алдагдлыг бууруулах мөн дотоодын долларын эрэлтийг тодорхой хэмжээнд бууруулах ач холбогдолтой талаар дурьдаж, “Засгийн газрын баталгаа нэмж гаргах хууль, эрх зүйн үндэслэл бүрдэх хүртэл дээрх асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна.” гэсэн хариуг ирүүлсэнг мэдэгдэж, зээлийн шугамыг нээж ашиглахаас өмнө дээрх асуудлуудыг тодорхой болгохыг анхааруулсан саналыг хүргүүлэв. -ЗГХЭГ-аас ирүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Хөрөнгө оруулалтын газраас боловсруулан ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын “Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжсэн. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын		
--	--	--	---	--	--

			“Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслүүдийг дэмжих тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Төрийн өмчийн хорооноос боловсруулсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжсэн хариуг ЗГХЭГ-т хүргүүлэв. -Төрийн өмчийн хорооноос боловсруулсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, дэмжсэн хариуг Сангийн яаманд хүргүүлэв. -Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын нэмэлт өөрчлөлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Засгийн газрын “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хооронд “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах” хөтөлбөрийн 2 дугаар үе шат, Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны хооронд “Бодлогын дүн шинжилгээ, хяналт шинжилгээний чадавхийг бэхжүүлэх” төслийг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тус тус тохиролцсоны дагуу асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Сангийн яамнаас боловсруулсан Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон Ерөнхий сайдын захирамжийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Улсын Их Хурлаас 2011 онд баталсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх, улмаар хөдөө аж ахуйг гаралтай бараа түүхий эдийн экспортын тоо хэмжээ, бүртгэлийг сайжруулах, төсөвт төвлөрүүлэх татварын хувь хэмжээг үнэн бодитой болгох зорилгоор Хүнс хөдөө аж ахуйн яамнаас боловсруулсан Засгийн газрын “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -Сангийн яамнаас боловсруулсан Гадаадын тусламжийн гэрээ, хэлэлцээ байгуулах асуудлыг зохицуулах шаардлагын үүднээс боловсруулсан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос орон нутагт шилжүүлэх дүнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Хүний хөгжлийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Сангийн яамнаас боловсруулсантай танилцаж, холбогдох 3 саналыг хүргүүлэв. -Сангийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын		
--	--	--	---	--	--

			хуралдааны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2015 оны төлөвлөгөөг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” тэмдэглэлийн төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, дэмжсэн саналыг Хууль зүйн яаманд хүргүүлэв. -Улсын Их Хурлын гишүүн С.Оюуны санаачлан боловсруулсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулиудын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, дэмжсэн хаиуг хууль зүйн яаманд хүргүүлэв. -“Үндэсний ажлын алба байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэл болон Монгол Улсын ерөнхий сайдын захирамжийн төсөл, холбогдох танилцуулгууд, Монгол Улсын гадаад яамаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулах Мянганы сорилтын гэрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх тухай хэлэлцээрийн төсөлтэй танилцаж, “Үндэсний ажлын алба байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн сангийн хөрөнгийг зарцуулах талаарх холбогдох зүйл, заалтыг тодорхой тусгах саналыг Хууль зүйн яаманд хүргүүлэв. -Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлийн санаачлан боловсруулсан Төв банк /Монгол банк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох танилцуулгатай танилцаж, дэмжсэн саналыг Хууль зүйн яаманд хүргүүлэв. -Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоолын хавсралтад “Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажил” концессын зүйлийг нэмэхээр Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дэмжив. -Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэхээр 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээр, уг төслийн танилцуулга, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл,		
--	--	--	--	--	--

				Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон Монгол Улсын Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй танилцаж, Монгол Улсын Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн нэрийг хуулийн төслийн үзэл баримтлалын нэртэй нийцүүлж “Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай” гэж өөрчлөх саналыг Сангийн яаманд хүргүүлэв. -Монгол Улсын Засгийн газрын “Монгол Улсын 2015 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийн 1 дүгээр заалтад “и/ гэрээний үндсэн дээр хийлгэж буй геологи, хайгуул, судалгааны ажлын төлбөр” гэсэн зориулалт, арга хэмжээг нэмж тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлэв. -Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж –ийн санаачлан боловсруулсан “Төсвийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж, хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг “Энэ хуулийг 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж өөрчлөн найруулах саналыг хүргүүлэв. -“Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг 2015 онд Монгол улсын Засгийн газар даргалах болсонтой холбогдуулан Удирдах ажилтнуудын уулзалт, сайд нарын уулзалт болон салбар хороодын хуралдаануудыг Улаанбаатар хотноо зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэхээр Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан Засгийн газрын “Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр” тухай тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, холбогдох 3 саналыг хүргүүлэв. -“Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкыг үүсгэн байгуулах хэлэлцээрийн тухай” Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг зарчмын хувьд дэмжсэн саналыг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлэв. -Аж үйлдвэрийн яамнаас боловсруулсан “Зээлийн авлага шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг дэмжив. -Сангийн яамнаас боловсруулсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан”-гийн тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, “Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжив. -“Монгол Улсын 2008-2014 оны төсвийн тухай хуульд тусгагдаж, тухайн төсвийн жилд бүрэн санхүүжигдээгүй, гэрээний үлдэгдэл төлбөр бүхий төсөл, арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг баталгаажуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон “Векселиэр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга		
--	--	--	--	---	--	--

			хэмжээний тухай” танилцуулгатай танилцаж дэмжсэн хариуг Сангийн яаманд хүргүүлэв. -Сангийн яамнаас боловсруулсан “Бүтцийн өөрчлөлттэй холбоотой зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж, холбогдох 2 санлыг хүргүүлэв. -Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах Жилийн санхүүжилтийн хөтөлбөрийн төслийн тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, Засгийн газрын дээрх шийдвэрүүдийн төсөлд тусгасан “Жилийн санхүүжилтийн хөтөлбөр” гэсэн нэр товъёог зориулалтын утгаар нь “2015 оны зээлийн санхүүжилтийн хөтөлбөр” гэж өөрчлөх саналыг Сангийн яаманд хүргүүлэв. -Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоолоор баталсан “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км авто зам”, “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км авто зам” төслүүдийн концессын гэрээний төслүүд, концессын гэрээ байгуулах тухай дүгнэлт, Монгол Улсын Засгийн газрын “Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” тогтоолын төсөлтэй танилцаж, тогтоолын төслийн 2 дугаар заалтыг “... тэнцэх төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг концессын гэрээнд заасан хөрөнгө оруулалтын эргэн төлөх хуваарийн дагуу тухайн жилийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд/Ж.Эрдэнэбат/, Аж үйлдвэрийн сайд/Д.Эрдэнэбат/ нарт тус тус даалгасугай.” гэж найруулан өөрчлөх саналыг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлэв. -Сангийн яамнаас боловсруулсан “Орон сууцны хорооллын санхүүжилтийн тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, дэмжив. -Ерөнхий сайдын 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаар Захирамжаар байгуулагдсан Монгол Улс, БНХАУ хооронд Замын-Үүд-Эрээний боомтыг түшиглэн дамнасан бүс байгуулах асуудлыг судлах Монголын талын ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж, дэмжсэн хариуг Аж шйлдвэрийн яаманд хүргүүлэв. -Аж үйлдвэрийн яамнаас 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03/1283 албан тоотоор ирүүлсэн Монгол-Японы засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан худалдаа хөрөнгө оруулалтын зөвлөлдөх уулзалтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Японын аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах сонирхол бүхий салбарын аж ахуйн нэгжүүдийн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг 2015 оны 5 дугаар сарын 11-ны 3/1150 тоот албан бичгээр АУЯаманд хүргүүлсэн. -Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас ирсэн “Хөдөө аж ахуйн хөгжлийн төв” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах тухай Засгийн		
--	--	--	---	--	--

			газрын тогтоолын төсөлтэй танилцан “Хөдөө аж ахуйн хөгжлийн төв”-ийн ерөнхий бүтэц, орон тоо, зардлын хувиарлалтын талаар тодорхой тусгах нь зүйтэй гэсэн саналыг 2015 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн албан тоотоор хүргүүлсэн. -Эрчим хүчний яамнаас ирсэн Нидерландын Гаг хотноо зохион байгуулагдах Эрчим хүчний Хартийн сайд нарын түвшний чуулга уулзалтанд оролцох айлчлалын үеэр баримтлах удирдамж, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулгатай танилцан зарчмын хувьд дэмжиж хариуг Эрчим хүчний яаманд 2015 оны 5 дугаар сарын 14 өдөр албан бичгээр хүргүүлсэн. -Гадаад хэргийн яамнаас ирсэн Хятад-Монгол-Орос талын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөр боловсруулах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлтэй танилцаж, саналыг 2015 оны 5 дугаар сарын 22-ны албан бичгээр хүргүүлсэн. -Сангийн яамаас ирүүлсэн “Орон сууцны зээлийн талаар авах арга хэмжээний тухай” засгийн газрын тогтоолын төсөл болон холбогдох бусад материалтай танилцан төслийг зарчмын хувьд дэмжин 2015 оны 6 дугаар сарын 19-нд албан тоотыг хүргүүлсэн. -“Жижиг, дунд үйлдвэрийг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төсөлтэй танилцлаа. Засгийн Газрын шийдвэрийн төсөл нь байхгүй тул санал өгөх боломжгүй гэж саналыг Хөдөлмөрийн яаманд 2013 оны 11 дүгээр сарын 21 өдрийн 1/2703 албан тоотоор хүргүүлсэн. -“Засгийн газрын комисс, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 19 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулахаар боловсруулсан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -“Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -“Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ын дагуу БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо 2015 оны 10 дугаар сарын 23-наас 27-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Монгол, Хятадын экспо” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Уул уурхайн яамны Түлшний бодлого, зохицуулалтын газрын дарга Л.Раднаасүрэн, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Энхбаяр нарын нэрийг хүргүүлэв. -Төсвийн тухай хуульд 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Сангийн яамнаас боловсруулан ирүүлсэн “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг		
--	--	--	--	--	--

			тооцох аргачлал”-ын төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлэв. Үүнд: -“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын төсөлд товчилсон үг их байгааг дэлгэрүүлж бичих; -Төрийн захиргааны төв байгууллага болон тэдгээрийн газар, хэлтсийн оноосон нэрээр нь бус хариуцсан чиг үүргээр нь өөрчилж бичих; -“Компани байгуулах тухай” Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж дараах саналыг хүргүүлэв. Үүнд:1.Тогтоолын төслийн 2 дугаар заалтыг “Бүтээн байгуулалтын лизингийн санхүүжилт охин компанийн дүрмийг батлахыг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д даалгасугай.” гэж өөрчлөх: 2.Тогтоолд дараах заалтыг нэмэх; “Бүтээн байгуулалтын лизингийн санхүүжилт” охин компаний үйл ажиллагаа жигдэрч, санхүүгийн хувьд бэхжихтэй уялдуулан хувийн хэвшлийг татан оролцуулж, Монгол Улсын Хөгжлийн банкны хувьцааны эзэмшлийг 51 хувь хүртэл бууруулах замаар хувийн хэвшлийн оролцоог хангаж, уг компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл/Б.Шинэбаатар/-д зөвшөөрсүгэй. -Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулж хуулийг хэрэгжүүлэх асуудлаар бэлтгэл ажлыг хангах, олон нийтэд хуулийг сурталчлан таниулах арга хэмжээ авахаар Сангийн яамнаас боловсруулсан “Хөрөнгө гаргах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж,Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хүрээнд нуун дарагдуулсан хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа ил болгон мэдүүлсэн хувь хүн хуулийн этгээдийн хувьд ийнхүү мэдүүлснийхээ төлөө хүлээх ёстой байсан хуулийн хариуцлага, үүргээс тус тус чөлөөлөгдөж, тэдгээрийн далд бизнесийг ил болгох боломжийг бүрдүүлж байгаа тул энэ хуулийн хэрэгжилтийн хугацаанд хариуцлага, үүргээс чөлөөлөгдөж буй хэн бүхэн аливаа сурталчилгаагүйгээр хуулийг дагаж мөрдөх нь дамжиггүй тул хуулийн сурталчилгаа болон хуулийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын сургалтанд Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргах нь зохимжгүй бөгөөд Татварын ерөнхий газарт ашиглах мэдээллийн технологийн төхөөрөмж болон хууль хэрэгжүүлэх 4 агентлагийн программ хангамжид зарцуулах нийт 390.0 сая төгрөгийн зардлын эх үүсвэрийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар Засгийн газрын тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэв. -“Авто замын барилгын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж, тогтоолын хавсралтын 18-д заасан төсөл, арга хэмжээний 2015 онд санхүүжих дүн болон, жагсаалтын хамгийн		
--	--	--	--	--	--

			сүүлийн мөрний нийт дүнг буруу тооцож тавьсан байх тул залруулах саналыг хүргүүлэв. -“Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны гэрээний Үндэсний зохицуулагчдын 38 дугаар чуулга уулзалт зохион байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж зарчмын хувьд дэмжив. -Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу БНХАУ-ын төрийн өмчит хуулийн этгээд “Powerchina Resources LTD” нь Монгол Улсын эрчим хүч, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлт, холбогдох материалуудтэй танилцаж, Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх хүсэлтийг дэмжив. -Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -“Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах, иргэдэд хувьцаа эзэмшүүлэх, иргэдийн хувьцааг Засгийн газар худалдан авах үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 3.11 дэх заалтыг өөрчлөхөөр боловсруулсан “Журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -“Зээлийн шугам ашиглах эрх олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт дахь “Их тэнгэр цогцолборыг АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын шаардлаад нийцүүлэн шинэчлэн засварлах төсөл”-ийн концессын гэрээний төсөлтэй танилцаж, Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг дэмжив. -“Чингис бонд-үндэсний үйлдвэрлэл” үзэсгэлэн худалдаа арга хэмжээг зохион байгуулахаар боловсруулсан “Арга хэмжээ зохион байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжив. -“Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк, Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны банкин дахь хувь хөрөнгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгатай танилцаж, зарчмын хувьд дэмжив. -“Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 189 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног		
--	--	--	--	--	--

			төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100.0 тэрбум төгрөг болон түүнээс дээш байхаар тогтоохдоо тооцоонд үндэслэн тогтоосон байх тул 100.0 тэрбум төгрөгийн хязгаарыг 5 дахин бууруулж, шууд 20.0 тэрбум төгрөг болгох нь татвараас бүрдэх улсын төсвийн орлогод сөргөөр нөлөөлөх магадлалтай тул Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 189 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд өөрчлөлт оруулахдаа Сангийн яамнаас өгөх саналыг харгалзах нь зүйтэй гэсэн саналыг хүргүүлэв. -“Ази Европын дээд түвшний арван нэгдүгээр уулзалтын аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 272 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан “Хөрөнгө гаргах тухай” тогтоолын төсөл, танилцуулгатай танилцаж, танилцуулга болон холбогдох материал дутмаг байгаа тул санал өгөх боломжгүй хариуг хүргүүлэв. -“Монгол Улсын Эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийг дэмжив. -“Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэлийн төсөл, Зээлийн ерөнхий хэлэлцээрийн төсөл, “Гарын үсэг зурах эрх олгох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж болон холбогдох танилцуулгатай танилцаж, Засгийн газрын тогтоолын төсөл болон Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн төслийг дэмжив. -“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолдын төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт Импорт банк хооронд байгуулах 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэлийн төсөл”-ийн нийт өртөгийг 55.2 сая ам.доллараар, зээлийн хэмжээг 46.92 сая ам.доллараар тусгасан Засгийн газрын тогтоолын төслийг Сангийн яамнаас танилцуулж байгаа болон мөн Зээлийн ерөнхий хэлэлцээрийн төслийн 5.5 дугаар заалтад “ ... Төслийн гэрээ тус бүрийн үнийн дүнгийн наян таван хүртэлхи хувийг (85%) санхүүжүүлэх ... ” гэсний дагуу “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын 3 болон 5 дугаар заалтад заасан төслийн ажилд шаардлагатай хөрөнгийн хэмжээ болон Монгол Улсын Хөгжлийн банкны гүүрэн санхүүжилтээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хувийг дээрх шийдвэрийн төсөлд тусгагдсан хэмжээтэй нийцүүлэх нь зүйтэй гэж үзэж саналыг хүргүүлэв. -Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Экспорт-Импорт банк хооронд байгуулах “Яармагийн хуучин гүүрийг засварлаж, шинэ гүүр барих төсөл”, “Гурилын үр тариа хадгалах элеватор барих төсөл”, “Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөл” тус бүрийн Тусгайлсан зээлийн		
--	--	--	---	--	--

32.				хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон холбогдох танилцуулгатай танилцаж тусгайлан өгөх саналгүй хариуг хүргүүлэв. -Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазарын санаачлан боловсруулсан “Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тусгайлан өгөх саналгүй хариуг хүргүүлэв. -“Хөгжлийн банкны үнэт цаас гаргах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тогтоолын төслийн 1 дүгээр заалтыг “... 25.56(хорин таван тэрбум таван зуун жаран сая) тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг Хөгжлийн банкны үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргах замаар бүрдүүлэхийг ...” гэж найруулан өөрчлөх саналыг хүргүүлэв. -Хийн түлш, хийн сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, тусгайлан өгөх саналгүй хариуг хүргүүлэв. Биелэлт 100%		
	84.		2.Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд Сайдаас өгөх саналыг боловсруулж хүргүүлнэ. Тоо хэмжээ: Өдөр тутам Чанар: Ирүүлсэн төсөлд хууль зүйн, санал дүгнэлтийг өгсөн байна. Хугацаа: Жилдээ	Засгийн газрын гишүүдээс санал авахаар ирүүлсэн хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөлд тухай бүрт Сайдаас өгөх саналыг боловсруулж хүргүүлсэн. Биелэлт 100%	30	
	424		4.3.18.2.Нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.	УУС-ын 2014 оны 12-р тушаалаар гарсан, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч зомпаниудын гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ахалж, байгуулагдсан гэрээнүүдийн 2013 оны хэрэгжилтэд х/ш/ү хийж дүнг яамны удирдлагад танилцуулж ажилласан.	30	

4.4 Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:

166.	425	4.4.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хэрэгжиж байгаа “Үндэсний хөтөлбөрүүд”-ийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг удирдлагуудад танилцуулан, ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГ-2013-322-ийн 17/	4.4.1.1.Үндэсний хөтөлбөрийн биелэлтэнд салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулан, ЗГХЭГ-т хүргүүлнэ.	"Бичил уурхай" болон "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах"дэд хөтөлбөрийн 2014 хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. "Бичил уурхай" дэд хөтөлбөр 78 хувь, "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах"дэд хөтөлбөр 84 хувийн биелэлттэй.	30	
167.	426	4.4.2. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төслүүдийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг удирдлагуудад танилцуулан, ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГ-2013-322-ийн 17/	4.4.2.1 Геологи, уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн биелэлтийг яамны газар, хэлтсүүдээс хагас жил, жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулан, ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Уул уурхайн яаманд хэрэгжиж байгаа “Кигам”, “Хасагт”, “Тогтвортой бичил уурхай”, “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох”, “Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структуурууд ба металлогени” зэрэг төслүүдийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагуудад танилцуулсан ба 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 1/794 тоотын хөвсрэлтаар ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 7/2147 тоотойр “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох” төслийн нэгжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагуудад танилцуулсан ба төслийн нэгжийн захирал Ж.Очирт хүргүүлсэн. Ерөнхий үнэлгээ 41 хувийн биелэлттэй. Улсын төсвийн санхүүжилтээр “Геомагнат ресурс” ХХК-иар гүйцэтгүүлсэн 634,8 сая төгрөг /гүйцэтгэлээр 584,8 сая төгрөг шилжсэн/-ийн гэрээний дүнтэй геологийн судалгааны “Жинст-50” төслийн гүйцэтгэлд дотоод аудит хийж дүгнэлт гарган удирдлагад танилцуулав.	30	

168.	427.	4.4.3. Геологи, уул уурхай, түлшний салбарт хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 4.4.3.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг яамны газар, хэлтсүүдээс хагас жил, жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна.	4.4.3.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг яамны газар, хэлтсүүдээс хагас жил, жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна.	Монгол Улсын 2011 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих Газрын тосны газрын чанарын хяналтын лабораторийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороо, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 34 дүгээр тушаалаар байгуулагдсан байна. Үнэлгээний хороо нь тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Бизнес фокус” ХХК-ийг шалгаруулж, 695.319,8 мянган төгрөгийн төсөвтэй гэрээ байгуулсан байна. 2013 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 108/2013 тоот “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын акт”-аар улсын комисс ашиглалтад хүлээн авсан. Яамны 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг 100 оноогоор үнэлж санал дүгнэлт, зөвлөмж боловсруулсан удирдлагад танилцуулсан.	27	
	428.	жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна	4.4.3.2.Нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.	Санал дүгнэлт, зөвлөмж боловсруулав.	27	
169.	429.	4.4.4. Төсвийн ерөнхийлөн захирагч/сайд/-ийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	4.4.4.1.Төсвийн ерөнхийлөн захирагч/сайд/-ийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг яамны газар, хэлтсүүдээс хагас жил, жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна	Яамны 2014 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 90,85 оноогоор үнэлж санал дүгнэлт, зөвлөмж боловсруулсан удирдлагад танилцуулсан. Газрын тосны газар 2014 онд хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ерөнхийлөн захирагчид хүргүүлж, Сайдын тушаалаар батлуулсан ба төсвийн жилийн явцад яаманд асуудал тавьж 3 арга хэмжээг нэмж оруулан өөрчлөлт хийсэн байна. Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 4 Үнэлгээний хороог байгууллагын даргын тушаалаар ажиллуулж, шууд худалдан авалтаар 2, харьцуулалтын аргаар 3, нээлттэй тендер шалгаруулалтаар 7 нийт 12 арга хэмжээг төлөвлөснөөс 11 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй байна. Чулуун дээжний агуулахын барилгын засварын ажил санхүүгийн эх үүсвэртэй холбоотойгоор дутуу биелэлттэй байна. • Харуул хамгаалалтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт 4 компани оролцсоноос чадавхийн шаардлага хангаж, улмаар хамгийн бага буюу батлагдсан төсвөөс 869.0 мянган төгрөгөөр бага үнийн санал ирүүлсэн “Хос харцага” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулж ажиллаж байна. • Түлш сатахуун нийлүүлэгчийг тодруулах тендер шалгаруулалтад “Сод монгол” ХХК, “Магнай трейд” ХХК-иуд оролцохоор материалаа ирүүлсэн боловч, чадавхийн шаардлага хангаагүй тул хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу бүх тендерээс татгалзаж, 2014 оны 3 сарын 18-нд дахин зарлаж шалгаруулалт явуулсан. Дахин тендер зарлахад “Магнай трейд” ХХК	30	

				ганцаар оролцож, 1 литр тутамд 50 төгрөгийн хөнгөлөлт үзүүлэх үнийн саналтайгаар шалгарсан байна. - Дархан-уул аймгийн төлөөлөгчийн газрын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 4 компани оролцож 33.148,5 мянган төгрөгийн үнийн саналаар "Их бага авгууш" ХХК шалгарсан байна. - Байгууллагын хуучин конторын засварт "Ажлын даалгавар"-ыг бэлтгэн, Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн мэргэшсэн төсөвчин Г.Пэлээсүрэнгээр хяналтын төсөв зохиолгон авч нээлттэй тендер шалгаруулалт зарлахад 6 компани оролцож 102.706,3 мянган төгрөгийн үнийн саналаар "Хан хайрхан" ХХК шалгарсан байна. - Төрийн өмчийн хорооны 2014 оны 246 тоот тогтоолоор төрийн байгууллагуудад шилжүүлсэн авто машинуудын нөхөн хангалтын ажлыг зохион байгуулахаар нийт 935.0 сая төгрөгийн 7 ширхэг тээврийн хэрэгслийг 3 багц болгон нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах ажлыг гүйцэтгэжээ. Үүнд: Багц-1: Хөдөө ажлын Ланд круйзер-76 маркийн суудлын автомашин 3 ширхэгийг худалдан авах тендерт "Хэт моторс" ХХК 240.000,0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан. Багц-2: Хөдөө ажлын суудлын автомашин Ланд круйзер-200-тай дүйцэх 3 ширхэг автомашин худалдан авах тендерт "Номин моторс" ХХК 390.000,0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан. Багц-3: Тусгай зориулалтын автобус 1 ширхэгийг худалдан авах тендерт "Хьюндай моторс Монгол" ХХК 158.500,0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан. - Байгууллагын хэрэгцээнд тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар гүйцэтгэж 2014 онд 4 компаниас 184.9 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, зураг төсөв, интерьерийн үйлчилгээ, 7 компаниас төлөөлөгчийн газруудын хэрэгцээнд 43.4 сая төгрөгийн тавилга техник хэрэгслийг худалдан авсан байна.		
	430		4.4.4.2.Нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.	Яамны 2014 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 90,85 оноогоор үнэлж санал дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулсан.	30	
170.	431	4.4.5. Салбарт хэрэгжиж байгаа хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж эхэлнэ.	4.4.5.1.Салбарт хэрэгжиж байгаа хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжилтийн явцыг яамны газар, хэлтсүүдээс хагас жил, жилийн эцсийн байдлаар хүлээн авч, салбар тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам", "Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам балах тухай" Уул уурхайн сайдын 2013 оны 41 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу гадаад дотоодын төрийн болон мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээр, санамж бичгийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.	15	

	432		4.4.5.2.Нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.	Гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн биелэлтэд 2014 оны жилийн эцсийн байдлаар хяналт, шинжилгээ үнэлгээ хийхэд, 100 хувийн биелэлттэй 1, 90 болон 70 хувийн биелэлттэй тус бүр 3, 50 хувийн биелэлттэй 4 заалт, 30 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ, ерөнхий дүнгээр 69,1%-ийн биелэлттэй үнэллээ. Тайланг яамны нэгдсэн тайланд хавсаргаж ЗГХЭГ-т хүргүүлэв.	15	
4.5. Төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөн, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:						
171.	433	4.5.1. Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээ болон холбогдох байгууллагуудад хяналт шалгалт хийх дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	4.5.1.1. Эрсдэлийн үнэлгээ хийж, дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	Сайдын 2015 оны 05 дугаарсарын 06-ны өдрийн 83 дугаартушаалаарУулуурхайнсайдындэргэдэх “Дотоодаудитынхороо”-гбайгуулж дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж ажилласан. 1. Уул уурхайн сайдын дэргэдэх Дотоод аудитын хороог хуралдуулан, 5 асуудал хэлэлцүүлж дотоод аудитын төлөвлөгөөг батлуулав. 2. Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээ болон холбогдох байгууллагуудад 2016 онд хяналт шалгалт, дотоод аудит хийх байгууллага, төслүүдийн жагсаалтыг Сангийн яаманд хүргүүллээ.	27	
175.	442	4.5.5. Төсвийн шууд захирагч болон гэрээ байгуулагч компаниудын хооронд байгуулсан хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд дотоод аудит хийнэ.	4.5.5.1.Төсвийн шууд захирагч болон гэрээ байгуулагч компаниудын хооронд байгуулсан хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамж боловсруулна.	Газрынтосныгазрынхөрөнгө оруулалт, худалданавахаажиллагааныхэрэгжилтэндбаримтыншалгалтхийждүгнэлтсаналз өвлөмжболовсрууланудирдлагадтанилцуулав.	30	
	443		4.5.5.2Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хамаарах баримт материалыг цуглуулж, нягтлан шалгах, шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгана.	Газрынтосныгазрынхөрөнгө оруулалт, худалданавахаажиллагааныхэрэгжилтэндбаримтыншалгалтыг газар дээр нь очиж гүйцэтгэв.	30	
176.	444	4.5.7. Дотоод аудитын хороо байгуулна.	4.5.7.1.Дотоод аудитын хороог байгуулах, хорооны ажиллах журмыг сайдын тушаалаар батлуулна.	“Дотоодаудитынхороо”байгуулахтухайсайдынтушаалынтөсөлдудирдлагуудаас саналавч, Сайдын 2015 оны 5 дугаарсарын 06-ны өдрийн 83 дугаартушаалаарУулуурхайнсайдындэргэдэх “Дотоодаудитынхороо”-гбайгуулав.	30	
	445		4.5.7.2.Дотоод аудитын хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.	Хэрэгжүүлэн ажиллаж байна. УУЯ-ны дотоод аудитын хорооны анхдугаар хуралдааныг зохион байгуулсан.	30	

177.	446.	4.5.8. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран салбарын томоохон аж ахуйн нэгжүүдэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийнэ.	4.5.8.1. Салбарын томоохон аж ахуйн нэгжүүдэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийнэ.	Салбарын томоохон байгууллагуудад 2016 онд хамтарсан дотоод аудит, санхүүгийн шалгалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлэв.	15	
	447.	салбарын томоохон аж ахуйн нэгжүүдэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийнэ.	4.5.8.2. Аудитын дүгнэлт зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулах, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.	Салбарын томоохон байгууллагуудад 2016 онд хамтарсан дотоод аудит, санхүүгийн шалгалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлэв.	15	
178.	448.	4.5.9. Уул уурхайн яам, агентлагуудын бусад аж ахуйн нэгжтэй байгуулсан санамж бичиг, гэрээнд дотоод аудит хийнэ.	4.5.9.1. Санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг хангуулна.	УУС-ын 2014 оны 12-р тушаалаар гарсан, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч зомпаниудын гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ахалж, байгуулагдсан гэрээнүүдийн 2013 оны хэрэгжилтэд х/ш/ү хийж дүнг яамны удирдлагад танилцуулж ажилласан. 1. Газрын тосны газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт боловсруулан удирдлагад танилцуулав.	30	
	449.		4.5.9.2. Дотоод аудитын дүнг удирдлагуудад танилцуулна.	ГТГ-т хийсэн аудитын дүнг удирдлагад танилцуулсан.	27	
ТАВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНЭЭС БУСАД ТҮЛШНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ОЙРЫН ЖИЛҮҮДЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ БОЛОН ХЭТИЙН ТӨЛӨВ, САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
5.1 Түлшний талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах гол зорилтын хүрээнд::						
Түлшний салбарын хууль тогтоомж, эрхзүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд:						
179.	450.	5.1.1 Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	1.Журмын төслийг боловсруулж Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.	Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төслийг боловсруулсан бөгөөд АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс санал авч төсөлд тусгасан. Мөн АНУ-ын худалдааны яам, Монгол дахь Элчин сайдын яамтай хамтран 3 хоногийн семинар зохион байгуулсан. Семинараас өгсөн зөвлөмжийн дагуу төслийг дахин боловсруулж, АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц хамтран зохион байгуулсан. 2015 оны 7 дугаар сард АНУ-д зохион байгуулсан сургалтад УУЯ, ГТГ-ын төлөөллүүдийг оролцуулсан. Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхайн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсний дараа ЗГХЭГ-т хүргүүлэн шийдвэрлүүлнэ.	15	
	451.	зарцуулах журмыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	2.Журмын төсөлд яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.			
180.	452.	5.1.2 Газрын тосны бүртгэл, тооцоо журмыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	1.Журмын төслийг боловсруулж Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.	Энэхүү журмын төслийг боловсруулж, АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс санал авч тусгасан. АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан семинараас өгсөн зөвлөмжийн дагуу төслийг дахин боловсруулсан. Журамтай холбогдуулан 2 удаа АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц зохион байгуулсан. Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхайн	15	
	453.	хэлэлцүүлнэ.	2.Журмын төсөлд яамдаас			

			санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсний дараа ЗГХЭГ-т хүргүүлэн шийдвэрлүүлнэ.		
183.	458	5.1.6 Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагыг боловсруулж, батлуулах арга хэмжээ авна.	1.Журмын төслийг боловсруулж, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагуудаас санал авч тусган, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.	Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын төслийг ГТГ-тай хамтран боловсруулж байна. Уул уурхайн яамны ТЗУГ, СБТГ-ын ГБХ, ГТГ-тай уулзалт зохион байгуулж, төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү шаардлагын төслийг боловсруулахад зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай байгаа бөгөөд энэ тухай саналыг АНУ-ын Элчин сайдын яам, Дэлхийн банкинд СБТГ-ын ЭЗХОХ-ээр дамжуулан уламжилсан. “Олон улсын газрын тосны менежмент систем” (2007/PRMS)-г даган мөрдөх талаар ГТГ-тай хамтран судалж байна.	15	

5.3 Газрын тостой холбогдсон үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд:

193.	476	5.3.1 Газрын тосны хайгуул, судалгаа, олборлолтыг эрчимжүүлнэ.	1.Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар сонгон шалгарсан аж ахуйн нэгжийн БХГ-г Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулна.	Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар сонгон шалгарсан Газрын тосны хайгуулын Увс-I, Хэрлэн тохой-XXVIII, Хар-Ус II талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох асуудлыг Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр, 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн гэрээ байгуулах шийдвэрийг гаргуулсан. Ингэснээр “Увс I” талбайн хайгуулын ажилд 257.57 сая ам.доллар, “Хэрлэн тохой XXVIII” талбайн хайгуулын ажилд 81.4 сая ам.долларыг зарцуулах бөгөөд 2 талбайд нийт 338.97 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэнэ. Мөн Газрын тосны хайгуулын Нэмэгт VI, Шарга III талбайд нээлттэй сонгон шалгаруулалтыг Уул уурхайн сайдын 2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 195 дугаар тушаалаар зарласан. -“Апекспро инвестмент лимитед” ХХК-ийн Дарьганга XXIV талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх эрх, үүргийг “Монголиа шин ий энерги” ХХК-д шилжүүлэх хүсэлт тавьсантай холбогдуулан ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулж, яамдуудаас санал авсан. Яамдын саналыг авч төсөлд тусган, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ. -Газрын тосны хайгуул, ашиглалтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын “Богд IV” ба “Онги V” талбайд Газрын тосны газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Сентрал азиан петролеум корпорэйшн лимитэд” ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн гэрээлэгчийн эрх, үүргийг “BG Mongolia holdings limited” компанид хэсэгчлэн шилжүүлэх асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан батлууллаа. -Их Британийн “BG Group”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар нийт 28 сая ам.долларын хөрөнгө оруулалт, 2016 онд 13 сая ам.долларыг хайгуулын ажилд, 1.4 сая ам.долларыг Засгийн газарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу зарцуулна. -Газрын тосны хайгуулын “Номгон IX” талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний	30	
------	-----	--	---	---	----	--

				эрх үүргийг шилжүүлэх Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан яамдын саналыг авч Засгийн газрын 2015 оны 300 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн.		
477	.		2.Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ҮАБЗ-д танилцуулан холбогдох зөвлөмжийг гаргуулна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 5-р сарын 19-ний өдрийн 77 дугаар зарлигаар 1995 оны 2-р сарын 22-ны өдрийн 39 дүгээр зарлигийг хүчингүй болгосноор ҮАБЗ-д танилцуулах шаардлагагүй болсон.	30	
478	.		3.Гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.	Засгийн газрын 2015 оны 4-р сарын 20, мөн оны 6-р сарын 15-ны өдрийн хуралдаанаар Увс-I, Хэрлэн тохой-XXVIII, Хар-Ус II талбайд БХГ байгуулах асуудлыг хэлэлцүүлэн гэрээг батлуулна.	30	
479	.		4.Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанид шинээр батлагдсан хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрлийг шинэчлэх арга хэмжээг авна.	2015 онд газрын тос хайх 6, ашиглах 1 тусгай зөвшөөрөл олгосон. Үүнд: Богд IV, Онги V талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах “Капкорп Монголиа” ХХК-д 2015 оны 58 дугаар тушаалаар, “Увс I” талбайд уламжлалт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах “Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК-д 2015 оны 113 дугаар тушаалаар, Номгон IX талбайд БХГ байгуулсан “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК-д 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 192 дугаар тушаалаар, Хар Ус II талбайд БХГ байгуулсан “Ренова Илч” ХХК-д 2015 оны 194 дүгээр тушаалаар, Хэрлэн тохой XXVIII талбайд БХГ байгуулсан “Монголиа Вэлпэк Индастриал” ХХК-д 2015 оны 227 дугаар тушаалаар газрын тос хайх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.	30	
480	.		5.Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд бодлогоор дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй БХГ 97 талбайд БХГ байгуулсан “Доншен газрын тос Монгол” ХХК-д уламжлалт газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 оны 212 дугаар тушаалаар олгосон. -Дорнод, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор аймагт 2015.05.20-06.22-ны хооронд орон нутаг дахь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа сэдэвт уулзалтуудыг зохион байгуулж, оролцохоор албан томилолтоор ажиллаж, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавьж ажилласан. -Газрын тосны хайгуулын Богд IV, Онги V, Номгон IX зэрэг талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүрэг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2015 оны 5-р сарын 04-ний өдрийн 172 дугаар тогтоол, 7-р сарын 20-ны өдрийн 3Г-ын 43 дугаар тэмдэглэлээр тус тус шийдвэрлүүлсэн. -Мөн 2015 онд гадаадаас Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүссэн аж ахуй нэгжүүдийн хүсэлтийг Хөдөлмөрийн яаманд уламжлан 3Г-ын 76, 112, 165, 233 дугаар тогтоолоор “Капкорп Монголиа” ХХК-46, Монголиа Гладвил Увс Петролиум” ХХК-96, Импайр газ ХХК-200, Дорнын хар алт ХХК-200, Петровичайна Дачин Тамсаг ХХК-1800, Эн Пи Ай ХХК-100, Доншен газрын тос Монгол ХХК-215 гадаадын мэргэжилтэн, мэргэжлийн ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлээ. -2015 онд газрын тосны хайгуулын 21 талбайд БХГ-ний дагуу хайгуулын ажил хийгдэхээс 12 талбайн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан. 2015 онд 12 талбайн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу нийт 65,4 сая	30	

				ам.долларын хөрөнгө оруулалтаар 350 км² талбайд 3D сейсм, 3585.2 тууш км 2D сейсм, 11000 км² талбайд агаарын бүрэн хэмжээст хүндийн хүчний судалгаа, 2400 км² талбайд хүндийн хүчний болон соронзон хайгуул, хайгуулын 10 цооног өрөмдөх, 10 цооногт каротажийн иж бүрэн судалгаа, туршилтын ажил хийгдэхээс 5 талбайд хайгуулын ажил хийгдэж байна. -Газрын тосны тухай хууль тогтоомж, БХГ-ний хэрэгжилтийн талаар иргэд, аж ахуй нэгжээс УИХ дахь Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн асуудлуудыг газар дээр нь шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх зорилго бүхий УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Ж.Батзандангаар ахлуул-сан ажлын хэсэгт орж 2015 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд газар дээр нь танилцаж, хяналт тавьж ажилласан. -Газрын тосны хайгуулын Тариач-XV талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний биелэлт хангалтгүй талаар ГТГ-аас ирүүлсэн хүсэлт, дүгнэлтийг үндэслэн гэрээг цуцлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох яамдаас санал авч тусган 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. -Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.2.17-д “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээ”-г байгуулж ажиллах тухай заасан бөгөөд тус гэрээний загварыг мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасны дагуу боловсруулж, Уул уурхайн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, яамдын санал авч Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.		
194.	481	5.3.2 Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	1.Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ97 гэрээт Зүүнбаян XIII, Цагаан-элс XIV талбайн олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд бодлогоор дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.	Монгол Улсын хэмжээнд 1998-2014 оны хооронд нийт 26.77 сая баррель буюу 3.61 сая тонн тос олборлож, 25,34 сая баррель буюу 3.40 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолж газрын тосны орлогоос нийт 527.98 сая ам.долларыг Монгол Улсын төсөвт төвлөрүүлсэн. 2015 онд нийт 7.72 сая баррель буюу 1.05 сая тонн газрын тос олборлож, экспортлон улсын төсөвт 162.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2015.11.01-ний байдлаар нийт 143.1 тэрбум төгрөг төвлөрүүллээ. -Мөн 2015 онд гадаадаас Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг Хөдөлмөрийн яаманд уламжилж ЗГ-ын 76, 165 дугаар тогтоолоор, Петрочайна Дачин Тамсаг ХХК-1800, Доншен газрын тос Монгол ХХК-215 гадаадын мэргэжилтэн, мэргэжлийн ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлсэн. -Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй БХГ 97 талбайд БХГ байгуулсан “Доншен газрын тос Монгол” ХХК-д уламжлалт газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 дүгээр сарын 06-ны өдрийн 212 дугаар тушаалаар олгосон.Бусад төрийн байгууллагуудтай харилцахад нь асуудлыг нь цаг тухайд уламжилж, дэмжлэг үзүүлж ажиллалаа.	30	

195.	482	5.3.3 Шинээр байгуулагдах бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх арга хэмжээ авна.	1.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулна.	Увс-I, Хэрлэн тохой-XXVIII, Хар-Ус II талбайн БХГ-үүдийг Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон шинээр батлагдсан гэрээний загварт нийцүүлэн боловсруулж байгуулсан. Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 2015 оны 9-р сарын 23-24-ний өдрүүдэд Газрын тосны газар, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай уулзалт, хэлэлцээр хийж, протокол байгуулсан. Үүнд: • Гэрээлэгч үйл ажиллагаандаа шаардагдах бараа, ажил үйлчилгаа худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид тэргүүн ээлжинд давуу эрх олгох; • Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монголын банк, санхүүгийн байгууллагаар дамжуулах; • Ажилчдын ажиллах оффис, амьдрах орон сууц, хоолны газар, спортын цогцолбор, мөн гаражийн барилгууд (суурин кэмп)-ын зураг төслийг монгол хэлээр орчуулж, баталгаажуулах, экспертизийн дүгнэлт гаргуулах болон барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг авах ажлуудыг хоёр тал хамтран яаралтай зохион байгууж, 2016 онд багтаан барилгын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах; • Тамсаг-XXI талбайн Та-2 Олборлолтын ил байгууламж руу татах хил дамнасан эрчим хүчний шугамын хилийн чандад баригдах хэсгийн барилгын ажлыг хэрхэн зохион байгуулах талаар 2 тал харилцан зөвшилцөж, оновчтой хувилбарыг сонгох; • Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомтын чиглэлийн 210,7 км хатуу хучилттай автозамын 1, 2-р хэсэг буюу 104,4 км замыг 2015 оны 12 дугаар сарын 31-ний дотор, үлдэж буй 3, 4-р хэсэг буюу 106,3 км замыг 2016 оны 12 дугаар сарын 31-н гэхэд ашиглалтанд оруулах; • Газрын тосны нарийн мэргэжлийн тоног төхөөрөмж, бараа материал, сэлбэг хэрэгслийг ГТГ хянаж, зөвшөөрсөний үндсэн дээр гадаадын үйлдвэртэй нь шууд гэрээ байгуулан худалдаж авах; • 2011 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах санхүүгийн шалгалтыг яаралтай дуусгах; • ОРТ программын мэдээллийн санд шаардлагатай байгаа мэдээллүүдийг ГТГ-т ирүүлэх. Мөн газрын тосны тухай хуультай нийцүүлэн шинээр БХГ байгуулсан аж ахуй нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг олголоо. Үүнд: “Увс I” талбайд уламжлалт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах “Монголиа Гладвилл Увс	30	
------	-----	---	--	---	----	--

				Петролиум” ХХК-д 2015 оны №113, Номгон IX талбайд “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК-д 2015 оны №192, Хар Ус-II талбайд “Ренова Илч” ХХК-д 2015 №194, Хэрлэн тохой-XXVIII талбайд “Монголиа Вэлпэк Индастриал” ХХК-д 2015 оны №227 дугаар тушаалаар газрын тос хайх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.		
5.4 Нүүрсний салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:						
197.	486	5.4.2 Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулагчаар талтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж бодлогын удирдамжаар хангаж ажиллана.	1. Тавантолгойн нүүрсний ордод 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэр барих ажилд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 18 дугаар захирамжаар Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох нээлттэй уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулагдсан. Энэхүү Ажлын хэсэг “Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим, удирдамж батлах тухай” УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоол, “Тавантолгойн ордыг ашиглах зарим асуудлын тухай” УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолуудыг удирдлага болгон Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ашиглах хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах гэрээний төслүүдийг боловсруулсан. -Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, Концессын гэрээний төслүүдэд нийт 22 санал төлөвлөж хүргүүлсэн.	27	
199.	488	5.4.4 Нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлнэ. ЗГҮАХ 103.1	1.Нүүрсийг хийжүүлэх үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлогыг боловсруулж Зг-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	Уул уурхайн сайдын 2015 оны 84 тоот тушаалаар “Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх” төслийн нэгжийн Удирдах хороог байгуулсан. Тус хорооны хурлаар төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталсан бөгөөд “Улаанбаатар хотын гэр хорооллыг хангах Нүүрсний хийн үйлдвэр” ба “Улаанбаатар хотын Хийн хангамж” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх хүсэлтийг Төслийг Уул уурхайн яамнаас 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 1/798 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталсан БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хавсралтад төслийг оруулж, 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газрын 135 тоот тогтоолоор батлуулсан. Үүний дагуу БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3 дугаар сараас 7 дугаар сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хийн дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос 3 компанийг сонгон авч, холбогдох ажлуудыг бэлэн болгосон ч, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг өөр төсөлд олгохоор шийдвэрлэсэн. Нүүрсхийжүүлэхтөслийннэгжийнүйл ажиллагааг эрчимжүүлэх талаар ЭрчимхүчнийСайдад “ДЦС-2 2015 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 1/431	30	

				албан тоот, МонголУлсаасБНХАУ-ынБээжинхотодсуух Элчин сайдад 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/714 албантоот, Сангийнсайдад 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн дугаар 1/798 албан тоотуудыг тус тус хүргүүлсэн. 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд Нүүрс хийжүүлэх SNG төслийн явц, талуудын хувь оролцооны талаар танилцуулсан. -Өнөөгийн байдлаар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 10 орчим компани төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эдгээрээс “Гранд Повер” ХХК нүүрснээс жилд 20 сая шоо метр хий үйлдвэрлэх үйлдвэрийг барьж, 2014 онд ашиглалтад оруулсан. Уул уурхайн яамны зүгээс агаарын бохирдлыг бууруулах зорилгоор энэхүү үйлдвэрийг өргөтгөн нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх туршилтын үйлдвэр барьж байгуулах төсөл хэрэгжүүлэх боломжтой байгаа талаар Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулсан. -“Гранд Повер” ХХК-ийн нүүрсний хийн үйлдвэрийг өргөтгөснөөр жилд 8500 ккал илчлэгтэй 2 сая шоо метр синтетик байгалийн хий үйлдвэрлэн 200 бар даралтаар баллонд савлаж, ахуйн хэрэглээнд хэрэглэх, автомашиныг хийн түлшээр цэнэглэх зэрэг боломж бүрдэх юм.		
5.5. Газрын тосны уламжлалт бус эх үүсвэрийг ашиглах, хөгжүүлэх зорилтын хүрээнд:						
200.	489	5.5.1 Хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалтад тавих стандарт, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулна. ЗГҮАХ 104.1	1.Хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалтад тавих стандарт, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулна.	Шингэрүүлсэншатдагхийнтүлшнийхэрэглээ, хангамж, нийлүүлэлттэйхолбогдсоннорм, дүрмийгболовсруулах үүрэгбүхийажлынхэсгийг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 110 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг гурван удаа хуралдсан бөгөөд АНУ-ын NFPA-58 стандартыг орчуулан боловсруулж байна. Мөн “Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээний аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн төслийг боловсруулж, Уул уурхайн Сайдын тушаалаар батлуулахад бэлэн болгосон.	27	
201.	491	5.5.2 Уламжлалт бус эх үүсвэрээс /нүүрсний давхаргын метан, занар, байгалийн битум, тослог элс г.м/ байгаль орчинд ээлтэй шингэн болон хийн түлш боловсруулах асуудлаар мэргэжлийн төрийн болон судалгаа, шинжилгээний байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үүсгэл санаачлагыг дэмжиж, үр дүнд хүргэнэ.	1.Нүүрсний давхаргын хий, шатдаг занарын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. 2. Шатдаг занарыг боловсруулах туршилт, судалгааны ажилд дэмжлэг үзүүлж ажиллана. 3. Нүүрсний давхаргын хийг ашиглах туршилт судалгааны ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.	“Эрдэнэс таван толгой” ХК Таван толгойн ордын Цанхи, Бортээгийн хэсэгт 120 км тууш 2 хэмжээст чичирхийллийн судалгааг хийж, тайлан боловсруулан зүсэлт зургууд гаргаж, нүүрсний давхаргын метан хий агуулах боломжтой давхаргуудыг тодорхойлсон. Тус ордын Бортээгийн хэсэгт нүүрсний давхаргын метан хий олборлох судалгааны 492 метр гүнтэй хий олборлох, 480 метрийн гүнтэй хий шахах 2 цооногийг гурван шатлалаар өрөмдөж, цементаци хийсэн бөгөөд нүүрсний давхаргын метан хийн нөөцийг 40 сая.тонн гэсэн төсөөллийг гаргасан. -Мөн БНСУ-ын Когаз корпорацийн нүүрсний давхаргын метан хийг цэвэрлэх туршилтын байгууламж 2015.8.12-нд ашиглалтад орсон бөгөөд туршилтын байгууламж нь нүүрсний давхаргын метан хийнээс ус, нүүрсхүчлийн хийг ялган метан хийг цэвэрлэх үүрэгтэй. Тус байгууламж дээр олборлож байгаа хийн хэмжээ бага бөгөөд хоногт 3 тонн орчим дагалдах ус олборлолтын явцад гарч байна. -“Эрдэнэс таван толгой” ХК болон БНСУ-ын Когаз компанийн гүйцэтгэж буй туршилтын ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, нэмэлт хайгуул судалгааны ажил эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Гадаад	30	

				харилцааны яаманд албан тоотоор хүсэлт хүргүүлсэн. Уг хүсэлтийн дагуу БНСУ-аас тус улсад суугаа Элчин сайдын яаманд нот бичиг хүргүүлж метан хийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх асуудлыг тавьсан. Монгол Улсад 2015 оны 12 дугаар сард БНСУ-ын Ерөнхийлөгчийн хийх дээд хэмжээний уулзалтын үеэр талуудын хэлэлцэх асуудлын ярианы сэдэвт метан хийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх асуудлыг тусгаж ажиллалаа.		
202.	494	4.1.18 Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. /Сайдын тушаал 2015.02.13-ны өдрийн 28 тоот тушаал/ 1.Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.		Газрын тосны тухай хуулийг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хуулийг даган гарах журам, зааврыг боловсруулах ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна. 2015.08.11-ний байдлаар: 1.“Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-ыгЗГ-ын 2015.03.16-ны өдрийн 104-р тогтоол, 2.“Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон холбогдсон харилцааг зохицуулах тухай”журмыг ЗГ-ын 2015.07.07-ны өдрийн 295-р тогтоолоор тус тус баталсан. 3.“Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам”-ыг УУ-н Сайдын 2014 оны 202 тоот тушаалаар баталж, ХЗЯ 2014.10.15-ны өдөр нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын жагсаалтад бүртгэсэн. 4.“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага”-ыг УУ-н Сайдын 2015.03.10-ны өдрийн 49 дүгээр тушаалаар батлуулсан. УУЯ-наас Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр 2015.07.24-ний өдөр хүргүүлсэн. 5.“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ын төслийг БОНХАЖ, УУ-н сайдын 2015.03.24-ний №62/А-131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсэг боловсруулсан. Журмын төслийг УУЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн саналыг тусгасан. Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. 6.“Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага”-ын төслийг боловсруулсан. Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Увс I, Хэрлэн тохой XXVIII талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-г Бүтээгдэхүүн хуваах гэрээний батлагдсан загвараар шинэ хуулинд нийцүүлэн байгуулсан. -Богд IV,Онги V талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах Капкорп Монголиа ХХК-д Уул уурхайн сайдын 2015 оны 3-р сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар газрын тос хайх, -“Увс I” талбайд уламжлалт газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах “Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК-д УУСайдын 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн 113 дугаар тушаалаар газрын тос хайх, - Номгон IX талбайд БХГ байгуулсан “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК-д 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 192 дугаар тушаалаар газрын тос хайх,	30	

				-Хар Ус II талбайд БХГ байгуулсан “Ренова Илч” ХХК-д 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 194 дугаар тушаалаар газрын тос хайх, -Хэрлэн тохой XXVIII талбайд БХГ байгуулсан “Монголиа Вэлпэк Индастриал” ХХК-д 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 227 дугаар тушаалаар газрын тос хайх тусгай зөвшөөрлийг олгосон. -Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй БХГ 97талбайд БХГ байгуулсан “Доншен газрын тос Монгол” ХХК-д уламжлалт газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 дүгээр сарын 06-ны өдрийн 212 дугаар тушаалаар олгосон. Газрын тосны тухай хуулийг шинэчилэн найруулсантай холбогдуулж хууль эрх зүйн орчны шинэчлэлийг сурталчилан таниулах ажлыг “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх бэхжүүлэх төсөл”-тэй хамтран гүйцэтгэлээ. ГТГнь “Жени Ойл Шейл Монголиа” ХХК-тай “Шатдаг занарыг газрын гүндin-situ аргаар боловсруулж, нийлэг хийн конденсат гаргах боломжийг тодорхойлох судалгааны ажлын гэрээ”-г 2013 оны 4 дүгээр сард байгуулсан. Гэвч орон нутгийн эсэргүүцлээс болоод эрлийн ажлаа хийж чадахгүй байсан тул “Жени Ойл Шейл Монголиа” ХХК -ийн шатдаг занарын эрлийн судалгааны ажил явуулах Төв аймаг, тус аймгийн Бүрэн суманд 2015.05.11, 2015.07.02-03-ны өдрүүдэд ажиллаж, аймаг, сумын удирдлагуудад “Газрын тосны тухай” хууль, эрлийн ажлыг танилцуулж, Гэрээлэгчийн шатдаг занарын эрлийн судалгааны үйл ажиллагаанд МУ-ын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг туслалцаа үзүүлэх уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтуудад Төв аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, Бүрэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга болон багийн засаг дарга нар, тус сумын төрийн албан хаагчид оролцсон. Уулзалтаар Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-р хэсгийн 6, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн 3.1 дэх хэсэг, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн 3.4.4-т Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.5 зэрэг заалтуудад тусгагдсан уламжлалт бус газрын тос (шатдаг занар)-ны эх үүсвэрийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх талаар тусгагдсан тухай, мөнэрлийн гэрээний талаар танилцуулсан. Газрын тосны тухай хуулийн 7.1.4-т заасан “Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон холбогдсон харилцааг зохицуулах тухай” журмын дагуу шийдвэрлэгдэнэ. Журмын төслийг боловсруулж Засгийн газрын 2015.07.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 295-р тогтоолоор батлуулсан. Одоогоор эрлийн 3 гэрээний дагуу шатдаг занарын хайгуул хийгдэж байгаа бөгөөд ажлын үр дүнгээс хамаарч туршилтын үйлдвэр байгуулах асуудал шийдвэрлэгдэнэ. Хөрөнгө оруулалтын талаар: 2015.08.07-ны байдлаар БХГ-т 11 талбайн 2015 оны хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан, нийт 65,4 саяам.долларын хөрөнгө		
--	--	--	--	---	--	--

			оруулалтаар 350 км2 талбайд 3D сейсм, 3585.2 тууш км 2D сейсм, 11000 км2 талбайд агаарын бүрэн хэмжээст хүндийн хүчний судалгаа, 2400 км2 талбайд хүндийн хүчний болон соронзон хайгуул, хайгуулын 10 цооног өрөмдөх, 10 цооног каротажийн иж бүрэн судалгаа, туршилтын ажил хийхээр төлөвлөсөн. “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны /хуучнаар/ шугамаар гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор айл өрхүүдэд хийн зуух хөнгөлөлттэй нөхцлөөр тараах ажлыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уг арга хэмжээнд “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ноос 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. ШШХ нь татваргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр Монгол Улсад орж ирж байгаа. Тиймээс татварыг бууруулна гэсэн эрх зүйн боломж байхгүй байна. Хөнгөлөлттэй зээлийн талаар Монгол банк болон бусад арилжааны банкуудад хандах нь оновчтой юм. Нүүрс хөтөлбөрийн төслийг боловсруулж Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаас өгсөн чиглэлийг тусган нэгтгэж Сайдын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан газрын тосны хайгуулын Увс-1, Хэрлэн тохой-28 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж хайгуулын салбарт 800 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байна. Газрын тосны тухай хуулийн 7.1.4-т заасан “Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон холбогдсон харилцааг зохицуулах тухай” журмын дагуу шийдвэрлэгдэнэ. Журмын төслийг боловсруулж, Засгийн газрын 2015.07.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.			
НИЙТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ					27,8	

ХОЁР. ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

ХАХ	ГА Ү	<i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуурзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 оноо)</i>

1.0. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:						
1.01. Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, мэдээллийн технологийн дотоод дэмжлэг үзүүлэх, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах гол зорилтын хүрээнд:						
1.02. Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг төлөвлөх, зохион байгуулах гол зорилтын хүрээнд:					ХШҮДАГ	ТЭЗ
